



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ГЭР БҮЛ ХӨДӨЛМӨР
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



**ТАНЫ ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА БОЛ ДАРААХ
БАЙГУУЛЛАГУУДАД ХАНДАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ, ЗӨВЛӨГӨӨ
АВАХ БОЛОМЖТОЙ.**

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Санал, өргөдөл, гомдол гаргах: 51-261553 (энгийн утасны тарифаар)

<https://mlsp.gov.mn/complain>

info@mlsp.gov.mn

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ)

(МҮЭХ-ны Хууль зүйн зөвлөгөө өгөх төв)

www.cmtu.mn

Зөвлөгөө, мэдээлэл авах, зөрчлийг мэдээлэх: 7011 9989, 1800-1292

Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Утас: 7053 3910

АЛБАДАН ХӨДӨЛМӨР

Албадан хөдөлмөр нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд **эрүүгийн гэмт хэрэг юм**. Хүн **өөрөө хүсээгүй** (буюу **сайн дураар зөвшөөрөөгүй**) байхад ямар нэг хэлбэрээр шийтгэж, эсхүл **шийтгэл хүлээлгэхээр сүрдүүлж (албадан)** ажил, үйлчилгээ гүйцэтгүүлбэл албадан хөдөлмөр болно¹.

Хүний эрх чөлөө, эрхэм чанарыг үгүйсгэдэг уг гэмт хэргийг бага цалин хөлс олгох, хөдөлмөрийн тааруу нөхцөлд ажиллуулах гэх мэт зөрчилтэй адилтгаж болохгүй. Эсхүл зөвхөн бие махбодын хувьд хүчирхийлэх, түгжиж цоожлох зэрэг илэрхий аргаар л хүнийг албадан хөдөлмөрлүүлдэг гэж ойлгох нь өрөөсгөл юм. Бодит амьдрал дээр албадан хөдөлмөр **маш олон янзаар илэрдэг** бөгөөд хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ил, далд байдлаар **албадах арга** ч улам нарийсаж байна.

Энэхүү хэвлэлийг АНУ-ын Хөдөлмөрийн Департаментаас IL- 39460-22-75-К-. дугаартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэв. Холбооны нөөцийн сангаас 100 хувь санхүүжүүлж буй олон улсын төслийн нийт төсөв 7.150.000 доллар. Энэхүү материал нь АНУ-ын Хөдөлмөрийн Департаментын үзэл бодол, бодлогыг илэрхийлээгүй бөгөөд аливаа худалдааны нэршил, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагыг дурдсан нь АНУ-ын Засгийн газар тэдгээрийг хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй болно.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд дараах шинж тэмдэг ажиглагдвал албадан хөдөлмөрийн эрсдэл байж болзошгүйг илтгэнэ². Үүнд:

Эмзэг байдлыг нь далимдуулах

Амьжиргаагаа залгуулах боломжгүй, тухайн орны хэл, хууль тогтоомжийг мэддэггүй, хөгжлийн бэрхшээлтэй, өр төлбөрт орсон, хууль ёсоор оршин суух зөвшөөрөлгүй гэх мэт тухайн хүний эмзэг, аргагүй нөхцөл байдлыг мэдэж, ашиглах. Тухайлбал, ажилтны ар гэрийнх нь хүн өндөр үнэ өртөгтэй эмчилгээ шаардах хүнд өвчин туссаныг мэдмэгц ердийн үед сайн дураараа зөвшөөрөхөөргүй дорд нөхцөл тулгах.

Чөлөөтэй зорчихыг хязгаарлах

Ажилтан ажлын байрандаа чөлөөтэй орж гарах боломжгүй, эсхүл ажлын байр, сууцанд нь түгжиж цоожлох, харуул хамгаалалт, хяналтын камерын тусламжтайгаар байнга хянах.

Заналхийлэх, айлган сүрдүүлэх

Ажилтныг маш олон янзаар сүрдүүлж айлган ажиллуулдаг. Ажлаас халахаас эхлээд эрх бүхий байгууллагад мэдэгдэх, цалин хөлс, хангамжийг нь хасах, давуу эрх, боломжийг нь хязгаарлах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг нь дордуулах зэргээр сүрдүүлдэг. Гэр бүлийн гишүүдийг нь заналхийлэх ч үүнд хамаарна.

Өрийн барьцаа, төлөөс болгох

Албадан хөдөлмөрийн хохирогчид ихэвчлэн өөрийн тавьсан болон өвлөгдөн дамжиж ирсэн өрийг дарах гэж ажилладаг байна. Цалин хөлсөө урьдчилгаа болгон авах, ажилд зуучлалын хөлс, тээврийн зардлаа төлөх гэж зээл авах, өдөр тутмын амьжиргааны болон бусад зардлаа төлөх зэргээс ийм өр төлбөр үүсэж болно. Мөн ажилтныг зориудаар өрөнд оруулах арга хэрэглэж, төлөөсөнд нь ажиллуулах явдал ч байна.

Цалингаар нь барьцаалах

Тухайн ажилтныг албадан үлдээж ажиллуулах, өөр ажилд орох боломжгүй болгох зорилгоор цалин хөлсийг нь зохион байгуулалттайгаар зориуд олгохгүй байх, хойшлуулах зэргээр барьцаалах.

Эдгээр шинж тэмдгийн аль нь ч шууд албадан хөдөлмөрийн нотолгоо болохгүй боловч тухайн хүн яагаад ийм нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч ажиллах болов гэсэн асуултыг эрхгүй дагуулдаг утгаараа албадан хөдөлмөр байж болзошгүйг илэрхийлэх хамгийн эхний сэжүүр юм. Хүн ажилд орохын өмнө, ажиллах явцдаа болон ажлаас гарах үедээ ч албадан хөдөлмөрт өртөж болно.

Хууран мэхлэх

Ажилтанд амаар болон бичгээр өгсөн амлалтаа биелүүлэхгүй байх. Албадан хөдөлмөрийн хохирогчдыг ихэвчлэн цалин хөлс сайтай, сайн ажилд оруулна гэж авсан ч бодит байдалд эдгээр амлалт хэрэгжихгүй байх нь бий.

Тусгаарлах

Ажилтныг гадна орчинтой холбогдох боломжгүй, алслагдмал газарт байлгах, холбоо харилцааны хэрэгслийг нь хураах, ажлын бус цагаар ч гар утас, интернет ашиглахыг зөвшөөрөхгүй байх.

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх

Ажилтныг эрхшээлдээ оруулахын тулд мансууруулах бодис, согтууруулах ундаа хүчээр хэрэглүүлэх, хүч хэрэглэн анх тохирсноос өөр ажил үүрэг албадан гүйцэтгүүлэх, хүчирхийллийг сахилгын арга хэмжээ болгох

Бичиг баримтыг барьцаалах

Ажилтны бичиг баримт, хувийн үнэ цэнтэй зүйлсийг ажил олгогч хураан авч барьцаалсны улмаас шаардлагатай үедээ авах боломжгүй, эсхүл эдгээр эд зүйлсээ орхиод ажлаасаа гарч чадахгүй байх.

Тэвчишгүй нөхцөлд ажиллуулж, амьдруулах

Ердийн нөхцөлд хүн сайн дураараа хүлээн зөвшөөрөхөөргүй дорд буюу бохир заваан, аюул эрсдэлтэй нөхцөлд ажиллуулах, ямар ч хувийн орон зайгүй, хэт шахцалдсан, наад захын эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд амьдруулах.

Илүү цагаар хэтрүүлэн ажиллуулах

Хууль тогтоомжид заасан хязгаараас хэтрүүлэн илүү цагаар ажиллуулах. Хэт уртасгасан цагаар ажиллуулахын зэрэгцээ зохих завсарлага, амралт олгохгүй, байнгын бэлэн байдалд уяатай юм шиг байлгах.

АЛБАДАН ХӨДӨЛМӨРӨӨС АНГИД БАЙХ ЭРХ ...

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, **Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц**од 2005 онд нэгдэн орсны зэрэгцээ Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар албадан хөдөлмөрөөс ангид байх эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хууль

...
Арван зургадугаар зүйл.
Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

...
4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. **Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.**
...

Хөдөлмөрийн тухай хууль

...
8 дугаар зүйл. **Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох**
8.1. **Хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.**
8.2. "Албадан хөдөлмөрлүүлэх" гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно.

8.4. **Хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн, албадан хөдөлмөрлүүлэхэд зуучилсан, зохион байгуулсан хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.**

Эрүүгийн хууль

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах

1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, **албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.**
2. Энэ гэмт хэргийг:
2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;
2.2. хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;
2.3. Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг:
3.1. байнга тогтвортой;
3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

13.13 дугаар зүйл. **Албадан хөдөлмөрлүүлэх**

1. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1 Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцын 2 дугаар зүйл (1930)

2 Албадан хөдөлмөр байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (2012)